



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 48


Сангиндалай

「Засаг даргын Тамгын газрын эзэмшилд буй
барилгын нэршил, үйл ажиллагааны чиглэлийг
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11, 35.12 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хийд 3-313 тоот хаягт байрших 658 кв талбай бүхий соёлын төвийн барилгын нэршлийг “Хүүхэд хөгжлийн ордон”, үйл ажиллагааны чиглэлийг малчид, хөдөлмөрчид, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх, хүүхдийг бүхий л талаар хөгжүүлэх чиглэлээр ажиллуулсугай.

2. Хүүхэд хөгжлийн ордны урсгал болон тогтмол зардлыг жил бүрийн төсөвтөө тусган үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг сумын засаг дарга (Б.Лхагвамандал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЧУЛУУН

